**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 06 өдөр                Дугаар А/367                Номгон

Дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд
шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал
ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.4, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Баянхөндий" төслийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах зөвшөөрлийг 2023 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаагаар "Эрдэнэ Монгол" ХХК (Петер Акерли)-д олгосугай.

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайн солбицол, ажлын тоо хэмжээг нэгдүгээр, дэвсгэр зургийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

3.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээ байгуулан хавсралтад заасан талбайгаас ажлын тоо хэмжээний дагуу ашиглаж, ажлын гүйцэтгэлийн тайланг сар бүр тайлагнаж, нөхөн сэргээлт хийж ажиллахыг "Эрдэнэ Монгол" ХХК (Петер Акерли)-д үүрэг болгосугай.

4.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээ байгуулж, холбогдох хууль, журмын дагуу ашигт малтмал ашигласны төлбөрийг төсөвт бүрдүүлж, нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавьж ажиллахыг Шинэжинст сумын Засаг дарга (Б.Бат-Эрдэнэ)-д, орлого бүрдүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Татварын хэлтэс (С.Рэнцэндагва)-д тус тус үүрэг болгосугай.

5.Төслийн бүтээн байгуулалтын ажилд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах талаар иргэд олон нийтэд мэдээлж, бүтээн байгуулалтын ажлыг дэмжиж ажиллахыг Шинэжинст сумын Засаг дарга (Б.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА                Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
А/367 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ТҮГЭЭМАЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТАЛБАЙН СОЛБИЦОЛ

| № | Нэр | Байршил | | | | Эргэлтийн цэгүүд | ТТАМ-ын хэмжээ /м3/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өргөрөг | Уртраг | X /UTM/ | Y /UTM/ | | |
| 1 | Хайрга, дайрга-1. | 43°55'51.78" | 98°47'29.50" | 483267 | 4864236 | X=483620 Y=4861828<br>X=484294 Y=4861724<br>X=485398 Y=4861395<br>X=485468 Y=4861368<br>X=485435 Y=4861274<br>X=484277 Y=4861625<br>X=483545 Y=4861753<br>X=483217 Y=4864236<br>X=483217 Y=4864286<br>X=483317 Y=4864286 | 10,000.00 |
| | Хайрга, дайрга-2. | 43°54'32.60" | 98°47'44.09" | 483586 | 4861792 | | |
| | Хайрга, дайрга-3. | 43°54'18.38" | 98°49'4.56" | 485379 | 4861349 | | |
| | Хайрга, дайрга-4. | 43°54'28.84" | 98°48'15.48" | 484286 | 4861675 | | |
| | Хайрга, дайрга-5. | 43°54'28.85" | 98°48'15.49" | 483396 | 4861315 | | |
| 2 | Элс-1. | 43°53'39.13" | 98°45'19.10" | 480325 | 4860151 | X=480400 Y=4860201<br>X=480400 Y=4860101<br>X=480250 Y=4860101<br>X=480250 Y=4860201 | 10,000.00 |
| | Элс-2. | 43°55'58.26" | 98°46'33.41" | 482017 | 4864439 | X=482092 Y=4864489<br>X=482092 Y=4864389<br>X=481942 Y=4864389<br>X=481942 Y=4864489 | |
| | Элс-3. | 43°56'50.55" | 98°48'28.80" | 484594 | 4866284 | X=484669 Y=4866334<br>X=484669 Y=4866234<br>X=484519 Y=4866234<br>X=484519 Y=4866334 | |
| | | | | | | | **20,000.00** |

________oOo________

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/307 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

N

# Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах талбайн байршлын зураг

